<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>481,300,000. 00</b>	<b>79,086,100.0 0</b>	<b>79,086,100.0 0</b>	<b>3,655,000.00</b>
2220 01	Тоног төхөөрөмж	0.00	0.00	0.00	3,655,000.00
2230 01	Бусад хөрөнгө	481,300,000. 00	79,086,100.0 0	79,086,100.0 0	0.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>212,297,600. 00</b>	<b>154,850,000. 00</b>	<b>0.00</b>	<b>154,850,000. 00</b>
2300 01	Эргэж төлөгдөх зээл	212,297,600. 00	154,850,000. 00	154,850,000. 00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛ ЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,967,027,80 0.00</b>	<b>1,518,180,33 5.73</b>	<b>1,620,696,01 3.00</b>	<b>- 1,582,646.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>1,195,984,21 3.00</b>	<b>- 1,195,984,21 3.00</b>
3100 01	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00	1,203,215,71 3.00	- 1,203,215,71 3.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,541,289,40 0.00</b>	<b>1,380,317,28 1.73</b>	<b>218,030,000. 00</b>	<b>1,263,220,31 3.00</b>
3200 01	Орон нутгийн төсвөөс	1,320,589,10 0.00	1,162,287,28 1.73	0.00	1,263,220,31 3.00
3200 02	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	220,700,300. 00	218,030,000. 00	218,030,000. 00	0.00

35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГ ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ААС</b>	<b>425,738,400. 00</b>	<b>137,863,054. 00</b>	<b>206,681,800. 00</b>	<b>68,818,746.0 0</b>
3500 01	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	141,557,100. 00	137,863,054. 00	137,863,654. 00	-600.00
3500 03	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	284,181,300. 00	0.00	284,181,255. 00	- 284,181,255. 00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	224,181,862. 60	0.00	224,181,862. 60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	467,926,961. 60	0.00	468,158,861. 60
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>58.00</b>	<b>58.00</b>	<b>0.00</b>	<b>58.00</b>
61	<b>БАЙГУУЛЛАГ ЫН ТОО</b>	<b>2.00</b>	<b>2.00</b>	<b>0.00</b>	<b>2.00</b>
6100 01	Төсвийн байгууллага	2.00	2.00	0.00	2.00
62	<b>АЖИЛЛАГСД ЫН ТОО</b>	<b>28.00</b>	<b>28.00</b>	<b>0.00</b>	<b>28.00</b>
6200 01	Удирдах ажилтан	9.00	9.00	0.00	9.00
6200 02	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	0.00	10.00
6200 03	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	0.00	7.00
6200 04	Гэрээт ажилтан	2.00	2.00	0.00	2.00
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>28.00</b>	<b>28.00</b>	<b>0.00</b>	<b>28.00</b>
6500 01	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00	0.00	11.00
6500 09	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00	0.00	9.00
6500 11	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00	0.00	8.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Могод сумын ЗДТГ нь Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд, Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, олон улсын байгууллагаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хөрөнгө, ОНХС-гийн хөрөнгийг зөв зохистой ашиглан хэрэгжүүлэх, иргэдийн оролцоо ил тод байдлыг хангах, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүн амаа өсгөх, сум орон нутгаа хөгжүүлэх, зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн тодорхой үр дүнд хүрэх зорилт тавин ажиллажээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Сумын ЗДТГ нь сумын ИХТ, Засаг даргын үйл ажиллагааны зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн зөвлөгөө дэмжлэгээр хангах, Төрийн үйлчилгээг чанар хүртээмжтэй шуурхай хүргэх, Нутгийн захиргааны байгууллагуудыг бодлогоор дэмжих, эрх зүйн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангах, Шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж, ололт амжилтыг урамшуулах, алдаа дутагдлыг засаж залруулах, сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг арга зүйн зөвлөмжөөр ханган төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Могод сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Могод сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 857.2 сая төгрөгөөр буюу 39.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	287.8	585.4	29.,6
Авлага	202.6	203.4	0.8
Бараа материал	79.6	107.9	28.3
Үндсэн хөрөнгө	1,606.6	2,137.2	530.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,176.7</b>	<b>3,033.9</b>	<b>857.2</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,176.7	3,033.9	857.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,176.7</b>	<b>3,033.9</b>	<b>857.2</b>

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 857.2 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлтэй байгаа нь сумын ОНХС-гийн 12 төсөл арга хэмжээний ажил хийгдээгүй 400.0 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй, байгууллагын эзэмшилд байгаа 408.5 сая төгрөгийн үнэтэй 16 газрыг орлого авч хөрөнгө нэмэгдсэн байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 585.4 сая төгрөг болж, өмнөх оноос 103.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	287,8	585,4	297,6
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	287,8	585,4	297,6

Арилжааны банк дахь харилцах			
<b>Гадаад валют</b>			
Арилжааны банк дахь харилцах			
Замд яваа мөнгөн хөрөнгө			
<b>Дүн</b>	<b>287,8</b>	<b>585,4</b>	<b>297,6</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 585.4 сая төгрөгөөс ОНХС-гийн дансанд 400.6, ХХС-гийн дансанд 45.1, БХС-гийн дансанд 13.3, ЖДҮДС-гийн дансанд 8.9, ерөнхий орлогын дансанд 117.2 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй тайлагнасан байна.

#### Аудитын илрүүлэлт

Сумын нөөцийн өвсний 700.0 мянган төгрөгийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн, сумын ЗД нөөц хөрөнгөөс сумын алдартнуудад 0.4 сая төгрөгийн бэлэг өгсөн, тушаал шийдвэргүйгээр 0.2 сая төгрөгийн тэтгэмж олгосон, үр дүнгийн урамшууллыг 0.1 сая төгрөгөөр илүү, ээлжийн амралтын цалинг 0.3 сая төгрөгөөр илүү тооцсон, тушаал шийдвэргүйгээр цалингийн нэмэгдэл 0.3 сая төгрөгөөр илүү олгосон зэрэг зөрчлүүдэд 6 төлбөрийн акт тогтоолоо.

Сумын ЗДТГ нь 0.4 сая төгрөгийн талбайн ажлын, 0.5 сая төгрөгийн сургалт явуулсан гэх боловч гэрээ байгуулж хэрэгжилтийг тооцоогүй зөрчлүүдэд 3, ОНХС-гийн төлөвлөсөн ажлууд дутуу хийгдсэнд 1 зөвлөмжийг, ОНХС-гийн 1.5 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчилд 1 албан шаардлага тус тус хүргүүлж ажилласан.

### **3.5.2 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 203.4 сая төгрөг болж, өмнөх оноос 0.8 сая төгрөгөөр өссөн байна.

#### *Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

Үзүүлэлт	<i>/сая төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага			
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Дансны авлага /ТӨҮГ/			
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/			
Татаас, санхүүжилтийн авлага			
Байгууллагаас авах авлага	82.7	66.1	-16.6
Хувь хүмүүсээс авах авлага	119.8	137.3	17.5
<b>Дүн</b>	<b>202.6</b>	<b>203.4</b>	<b>0.8</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга тайлангаар ХХС-гийн дансанд 180.7, ЖДҮДС-гийн дансанд 22.7 сая төгрөгийн авлагын эцсийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Төсөвт байгууллагууд авлагын үлдэгдэлгүй байна.

**Аудитын илрүүлэлт**

Завсрын аудитаар өвс тэжээлийн 3.3 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй зөрчил илэрснийг жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулсан. Мөн ХХС-гийн 2013-2014 онуудад олгосон, олон жил болсон 2 иргэний 28.0 сая төгрөгийн зээлийг одоо болтол барагдуулаагүй, төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүйд 1 албан шаардлага бичлээ.

Өмнөх оны санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй ОНХС-гаар 17.3 сая төгрөгийн төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг олгосонд 1 зөвлөмж хүргүүлсэн.

**3.5.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэлгүй болно.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал			
Урьдчилгаа тооцоо			
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			
Дүн			

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Аудитын илрүүлэлт:**

Аудитаар зөрчил илрээгүй болно.

**3.5.4 Бараа материал**

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 107.9 сая төгрөг болж, өмнөх оноос 28.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>			
Тусгай зориулалттай материал			
Эм боох материал			
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>			
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>			
<b>Хангамжийн материал</b>			

Бичиг хэргийн материал	3.0	2.4	-0.6
Аж ахуйн материал	21.7	15.6	-6.1
Сэлбэг хэрэгсэл			
Түлш, шатах тослох материал			
Барилгын засварын материал			
Хүнсний материал			
Бусад хангамжийн материал	53.6	85.9	32.3
<b>Мал амьтад</b>	<b>1.3</b>	<b>4.0</b>	<b>2.7</b>
<b>Дүн</b>	<b>79.6</b>	<b>107.9</b>	<b>28.3</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт 76.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 31.0 сая төгрөгийн орлого хүлээн авч, 78.3 сая төгрөгийн материал зарцуулж эцсийн үлдэгдэл 107.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Энэ нь сумын ЗДТГ 68.2, ИТХ 3.7, ЖДҮДС 36.0 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй тайлагнажээ.

#### Аудитын илрүүлэлт

Сумын ИТХ нь бараа материалын тодруулга тайланд 0.2 сая төгрөгийн материалын орлого дутуу тайлагнасан алдааг залруулсан.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэлгүй болно.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад			
Дүн			

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй болно.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,137.2 сая төгрөг болж, өмнөх оноос 530.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>			
Барилга, байгууламж, орон сууц	1,224.8	1,200.8	-24.0
Авто-тээврийн хэрэгсэл	32.7	88.3	55.6

Машин тоног төхөөрөмж(компьютер)	94.7	78.0	-16.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	104.0	82.5	-21.5
Бусад үндсэн хөрөнгө	14.0	143.4	129.4
Дуусаагүй барилга, байгууламж			
<b>Биет бус хөрөнгө</b>			
Программ хангамж	2.0	1.4	0.6
Бусад биет бус хөрөнгө	134.4	542.9	408.5
<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>			
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/			
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад			
<b>Дүн</b>	<b>1,606.6</b>	<b>2,137.3</b>	<b>530.7</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө 530.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь биет бус хөрөнгө буюу газар нэмж орлого авч тайлагнасантай холбон үзэж байна.

Аудитын илрүүлэлт:

ОНХС-гаар хийгдсэн 20.0 сая төгрөгийн малын угаалгын ванныг, сумын ЗДТГ-ын эзэмшилд байгаа 408.5 сая төгрөгийн 16 газрыг үнэлж тайланд тусгаагүй, 11 төрлийн 4.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг данс бүртгэлээс хасаж тайлагнаагүй 3 алдааг залруулж, сумын ЗДТГ-ын шинээр 10 газар авсан гэх боловч гэрчилгээг авч ажиллаагүй зөрчилд 1 зөвлөмж хүргүүллээ.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэлгүй болно.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Дүн			

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 667.2 сая төгрөг болж, өмнөх оноос 408.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	258.7	667.2	408.5
Өмч /төрийн/ /ТӨҮГ/			
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,766.5</b>	<b>2,216.7</b>	<b>450.2</b>
Өмнөх үеийн үр дүн	3,895.2	1,766.5	-2,128.7
Тайлант үеийн үр дүн	-2,126.6	450.2	-1,676.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	150.1	150.1	0
<b>Дүн</b>	<b>2,176.7</b>	<b>3,033.9</b>	<b>857.2</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо нэмэгдсэн нь биет бус хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,966.0, үйл ажиллагааны орлогоос 1.0 сая төгрөг буюу нийт зарлагыг 1,967.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн IX/05 дугаар ИТХ-ын тогтоолоор төсвийн төслийн саналаас зардлыг 486.3 сая төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 1480.7 сая төгрөгөөр, татварын болон татварын бус орлогыг 401.6, санхүүгийн дэмжлэг 218.0 сая төгрөгөөр бүрдүүлэхээр тус тус баталсан байна.

Төсвийн тодотголоор 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн XII/01 ИТХ-ын тогтоолоор төсвийн нийт зардлыг 1967.0 сая төгрөгөөр өөрчлөн баталсан байна.

Энэ нь малын тоо толгойн 2021, 2022 онуудын татварын орлогын үлдэгдлийг 30.6 нэмэгдүүлж, цалин хөлс нэмэгдсэнтэй холбож цалингийн зардлыг 20.9, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 220.2, ОНХС-гийн санхүүжилтийн орлогыг 47.2, сангуудын орлогыг 118.7, өмнөх оны үлдэгдлээс 48.8 сая төгрөгийг зарцуулах болсонтой холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор 486.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 17 хөтөлбөрийн 103 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,966.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээр, сумын орлогыг 401.6 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,400.7, нэмэлт санхүүжилтийн дансаар 11.5, үндсэн үйл ажиллагааны орлогоос 137.8, сумын татварын орлогоос 387.8, татварын бус орлогоос 9.4 сая төгрөгийг тус тус төвлөрүүлж нийт 2,947.2 сая төгрөгийн санхүүжилтийн орлогоор тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,649.6 сая төгрөг буюу 89.9 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оны мөнгөн хөрөнгийн 287.8 сая төгрөгийн үлдэгдэл дээр цэвэр мөнгөн гүйлгээний 297.5 сая төгрөг нэмэгдэж нийт 585.4 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Энэ нь ОНХС-гийн дансанд 400.6, ХХС-гийн дансанд 45.1, БХС-гийн дансанд 13.3, ЖДҮДС-гийн дансанд 8.9, ерөнхий орлогын дансанд тогтмол зардлын 100.7, сумын давсан орлогын 16.5 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/сая төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ЗДТГ 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	490.2	472.3	17.9	96.3
2	ИТХ 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	105.9	105.8	0.01	99.9
3	ИТХ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	0.3	0.2	0.1	66.7
4	ИТХ 80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	5.1	2.4	2.7	47
5	ИТХ 82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	1.8	1.8	0	100
6	ОНХС Итгэлцүүрээр олгох, Малын тоо толгойн албан татвар	479.7	79.1	400.6	16.4
7	ХХС Дотоод эх үүсвэрээр олгох зээл	123.0	77.9	45.1	63.3
8	БХС Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	13.7	13.2	0.5	96.3
9	ЖДҮДС Дотоодын эх үүсвэрээр олгох зээл	85.8	76.9	8.9	89.6
10	ЕБС 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	223.3	186.8	36.5	83.6
11	СӨБ 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	43.1	34.9	8.2	81
12	ЭМТ 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	57.3	37.2	20.1	65
13	Соёл 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	31.9	28.4	3.5	89
14	ЗДТГ 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	93.7	83.2	10.5	88.8
15	ЗДТГ 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	40.0	39.7	0.3	99.2
16	ЗДТГ 82801 Улсын их баяр наадам	5.0	5.0	0	100
17	ЗДТГ 82212 Хог хаягдал орчны бохирдол	4.6	4.5	0.1	97.8

18	ЗДТГ 80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	3.6	3.6	0	100
19	ЗДТГ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	34.3	33.6	0.7	98
Нийт дүн		1,842.3	1,286.5	555.7	70

Дээрх хүснэгтээс харахад нийт хөтөлбөрийн үзүүлэлт 1,286.5 сая төгрөг буюу 70 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь сумын ОНХС-гийн ажил бүрэн хийгдээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар 11.5 сая төгрөгийн санхүүжилтийг сумын ЗДТГ нь аймгийн ЗДНХ-өөс нэмэлтээр санхүүжилт авсан байна.

Гүйцэтгэлээр ахмадын холбооны байрны засварт 5.0, малын тоо, нэгдсэн бүртгэлийн мэдээ оруулах судалгаа, хог зэм устгах ажлын шатахууны зардалд 2.7, ус рашаан ашигласны төлбөрт 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/сая төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Могод сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн

үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Могод сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/89 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүү үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүү үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн зарлагын 2059.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 30.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сумын ИТХ нь 4.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, сумын ЗДТГ нь хөрөнгө бэлтгээгүй байна.

Мөн тус сумын ОНХС, БХС-гаар хийгдэх төсөл арга хэмжээний ажлууд хийгдээгүй, батлагдсан орон тооны хүрээнд үйл ажиллагааг явуулжээ.

#### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд шилэн дансанд 144 мэдээлэл тайлагнахаас мэдээллийг бүрэн тайлагнаж ажилласнаас 6 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл гэсэн 46.8 сая төгрөгийн 2 мэдээд хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрсэн.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Зөвлөмж хүргүүлээ.

Сумын ЗДТГ, ИТХ, Соёлын төв, ОНХС-гийн шилэн дансанд мэдээлэх мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлээгүй зөрчлүүд илэрсэнд 4 зөвлөмж хүргүүлээ.

#### **4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Могод сум нь 2023 онд 14 төрлийн татварын болон татварын бус орлогоос 401.6 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 397.1 сая төгрөг буюу 98.9 хувиар орлого оруулсан байна.

Сумын ОНХС-гийн 400.6, БХС-гийн 6.7 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдэх ажлууд цаг хугацаандаа хийгдээгүй мөнгөн гүйлгээний тайланд эцсийн үлдэгдлээр тайлагнасан зөрчлүүд илэрсэн.

##### Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж хүргүүлсэн.

Сумын нөөцийн өвсний 0.7 сая төгрөгийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.4-т “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.7.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар тус сумын 2023 оны ЖДҮДС-гийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад өвс, тэжээлийн 3.3 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй алдаа залруулах алдаагаар, 0.7 сая төгрөгийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоож аудитын алдаа зөрчилтэй асуудлын бүртгэлээр танилцуулан баталгаажуулж ажилласан.

Дээрх алдаа зөрчилтэй асуудлыг сумын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилд нэгтгэж ажиллалаа.

##### **4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг 2023 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлжээ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	16,930.4	1	16,930.4	100
Албан шаардлага					
Зөвлөмж	2	5,276.8	2	5,276.8	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>22,207.2</b>	<b>3</b>	<b>22,702.2</b>	<b>100</b>

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын ИТХ-аар батлуулсан БХС болон ОНХС-гаар хийгдэх ажлуудыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байх шаардлагатай байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10.8 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 3.3 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6.8 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Үүнд: Өвс, тэжээлийн 3.3 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй алдааг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэж заасны дагуу алдааг залруулж ажиллалаа.

Аудитаар нийт 7.5 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 0.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 6.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

Сумын нөөцийн өвсний 0.7 сая төгрөгийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13 дугаар зүйлийн 6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-т "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Төсөв хөрөнгөтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

БХС-гийн 6.7 сая төгрөгөөр хог хаягдал, тэрбум модны хүрээнд мод тарих ажлыг сумын ИТХ-аар батлуулж ажилласан ч тухайн жилд тус ажлуудыг хийж гүйцэтгээгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

БХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлыг төлөвлөсөн цаг хугацаанд хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	3.3	1	3.3			1	3.3				
ЗДТГ	3	433.2	3	433.2			3	433.2				
ИТХ	1	0.2	1	0.2			1	0.2				
Дүн	5	436.7	5	436.7			5	436.7				

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	2	7.5	1	0.7			1	6.8				
ЗДТГ	4	1.2	2	0.3			2	0.9				
ИТХ	1	0.3	1	0.3								
Соёлын төв	1	0.3	1	0.3								
ОНХС	3	46.8			2	29.5	1	17.3				
Дүн	12	56.1	5	1.6	2	29.5	5	25.0				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	1	46.8					1	46.8
ЗДТГ	1	0					1	0
ИТХ	1	0					1	0
Соёлын төв	1	0					1	0
ОНХС	1	0					1	0
Дүн	5	46.8					5	46.8
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	1	0.4	1	0.4				
Дүн	1	0.4	1	0.4				
Нийт дүн	6	47.2	1	0.4			5	46.8